



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/416

Алтай хот

Байгууллагын нэр өөрчилж, бүтэц,
орон тоо, албан хаагчдын чиг үүргийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 168 дугаар тогтоол, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2013 оны А/315 дугаар тушаалын хавсралт "Аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 33 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрыг Боловсролын газар болгон өөрчилсүгэй.


2. Боловсролын газрын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Баталсан бүтэц орон тоог мөрдөж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж ажиллахыг Боловсролын газар (Т.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг)-т үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/699 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР